БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян Өлгий аймгийн нэгдсэн эмнэлэг 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БӨА-2024/003/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn
Өлгий хот
2023 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор: Ж.Айгүл

Утас: 70422954 Цахим хаяг: Aigulj@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Назгүл

Утас: 99427301 Цахим хаяг: NazgulD@audit.gov.mn

Ахлах аудитор: М.Айнур
Утас: 94159291 Цахим хаяг: ainurm@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

1. Хараат бус аудиторын дүгнэлт

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт

4. Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

4.2 Материаллаг байдал

4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

5. Аудитын илрүүлэлт

6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

2025. 02. 25 № 332
танай ______ -ны № ______ -т

БАЯН ӨЛГИЙ АЙМГИЙН
НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ДАРГЫГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Н.ЕРЖАН ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян Өлгий аймгийн нэгдсэн эмнэлгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Баян Өлгий аймгийн нэгдсэн эмнэлгийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд онцлох асуудал гараагүй байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

83250200009

**Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.АЙГҮЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,846,024,952.54** | **1,637,619,633.71** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **1,464,000.00** | **82,800.00** |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 1,464,000.00 | 82,800.00 |
| **33** | **АВЛАГА** | **595,224,301.00** | **442,524,922.65** |
| 33402 | Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/ | | |
| **335** | **Бусад авлага** | **595,224,301.00** | **442,524,922.65** |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 595,224,301.00 | 442,524,922.65 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **1,249,336,651.54** | **1,195,011,911.06** |
| **351** | **Түүхий эд материал** | **856,658,649.04** | **724,434,262.86** |
| 35130 | Эм боох материал | 856,658,649.04 | 724,434,262.86 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 20,000.00 | 20,000.00 |
| **354** | **Хангамжийн материал** | **392,658,002.50** | **470,557,648.20** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 14,158,564.90 | 25,608,364.90 |
| 35420 | Аж ахуйн материал | 136,332,504.67 | 190,656,100.37 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 1,866,591.69 | 1,866,591.69 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 4,209.95 | 4,209.95 |
| 35450 | Барилгын засварын материал | 39,542,999.37 | 46,604,049.37 |
| 35460 | Хүнсний материал | 55,086.50 | 55,086.50 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 200,698,045.42 | 205,763,245.42 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **31,591,677,711.64** | **31,391,387,591.23** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **31,591,677,711.64** | **31,391,387,591.23** |
| 391 | Газар | | |
| **392** | **Биет хөрөнгө** | **31,037,916,438.44** | **30,848,934,042.45** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 14,549,564,140.09 | 14,646,203,628.09 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (1,703,488,334.39) | (2,069,363,759.51) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 997,212,664.00 | 1,598,126,978.30 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (366,607,953.48) | (475,593,390.10) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 14,392,028,586.16 | 14,360,033,683.97 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (7,911,421,661.87) | (8,249,831,826.07) |

| | | | |
|---|---|---|---|
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 651,154,306.13 | 651,893,738.84 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (240,891,226.51) | (270,926,718.10) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 170,453,545.36 | 170,453,545.36 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (53,923,139.51) | (65,897,350.79) |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | 10,552,899,449.00 | 10,552,899,449.00 |
| 39217 | Ном | 936,063.46 | 936,063.46 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **553,761,273.20** | **542,453,548.78** |
| 39301 | Програм хангамж | 58,062,122.00 | 58,832,122.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (19,304,848.80) | (28,095,773.22) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 515,079,500.00 | 515,079,500.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | (75,500.00) | (3,362,300.00) |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **33,437,702,664.18** | **33,029,007,224.94** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **1,700,507,353.49** | **2,173,675,732.65** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **1,700,507,353.49** | **2,173,675,732.65** |
| **413** | **Өглөг** | **1,700,507,353.49** | **2,173,675,732.65** |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 11,519,738.00 | - |
| **4136** | **Бусад өглөг** | **1,688,987,615.49** | **2,173,675,732.65** |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 956,782,312.58 | 1,628,664,718.38 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | | 9,980,200.00 |
| 41363 | Татварын өглөг /ТӨҮГ/ | 247,144,680.37 | 42,777,574.52 |
| 41364 | НДШ - ийн өглөг /ТӨҮГ/ | 202,435,810.79 | - |
| 41366 | Дансны өглөг /ТӨҮГ/ | 282,624,811.75 | 492,253,239.75 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **31,737,195,310.69** | **30,855,331,492.29** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **31,737,195,310.69** | **30,855,331,492.29** |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | **4,633,020,649.16** | **4,633,020,649.16** |
| 51101 | Өмч: - төрийн | 4,633,020,649.16 | 4,633,020,649.16 |
| 51102 | - хувийн | | |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **18,782,324,463.79** | **17,900,953,968.59** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 18,782,324,463.79 | 18,782,817,786.99 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (881,863,818.40) |
| 51230 | Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс | - | - |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 8,321,850,197.74 | 8,321,356,874.54 |

| | | | |
|---|---|---|---|
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **33,437,702,664.18** | **33,029,007,224.94** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **18,265,437,978.79** | **22,997,287,518.66** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **3,828,454,997.79** | **2,062,043,592.66** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **589,388,207.11** | **2,062,043,592.66** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | **589,388,207.11** | **481,171,210.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 411,094,554.28 | 481,171,210.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 178,293,652.83 | - |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | - | 1,528,859,044.96 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | - | 52,013,337.70 |
| **122** | **Тусламжийн орлого** | **3,239,066,790.68** | **-** |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 3,239,066,790.68 | |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **14,436,982,981.00** | **20,935,243,926.00** |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **-** | **1,124,724,000.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | | 1,124,724,000.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | **14,436,982,981.00** | **19,810,519,926.00** |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 14,436,982,981.00 | 19,810,519,926.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **18,792,147,379.53** | **23,879,151,337.06** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **18,792,147,379.53** | **23,879,151,337.06** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **18,787,328,379.53** | **23.877.751.335.06** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **9,701,653,881.89** | **13,235,620,293.08** |
| 210101 | Үндсэн цалин | 9,701,653,881.89 | 13,235,620,293.08 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **1,213,552,784.70** | **1,709,113,299.21** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 1,213,552,784.70 | 1,709,113,299.21 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | - | - |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | - | - |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | - | - |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | - | - |
| 210206 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | | |

| | | | |
|---|---|---|---|
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **1,400,231,358.29** | **1,559,435,962.42** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 157,181,173.00 | 186,920,954.42 |
| 210302 | Түлш, халаалт | 943,050,185.29 | 1,072,515,008.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 300,000,000.00 | 300,000,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **621,525,912.00** | **700,589,421.97** |
| 210401 | Бичиг хэрэг | 97,638,570.00 | 132,173,540.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 299,665,480.00 | 256,590,250.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 9,626,822.00 | 11,629,569.97 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 94,024,000.00 | 98,610,400.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 880,000.00 | 9,216,212.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 119,691,040.00 | 192,369,450.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **3,964,017,329.06** | **4,717,540,652.04** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 3,527,696,397.06 | 4,195,482,602.04 |
| 210502 | Хоол, хүнс | 434,155,932.00 | 501,564,050.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,165,000.00 | 20,494,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **53,343,354.00** | **60,150,472.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 13,548,400.00 | 1,443,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 39,794,954.00 | 58,707,472.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **49,988,200.00** | **74,778,384.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 49,988,200.00 | 74,778,384.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **19,208,700.00** | **22,191,294.97** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 10,800,000.00 | 7,000,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 210,000.00 | 630,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 4,125,900.00 | 7,725,974.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 699,400.00 | 455,350.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 407,000.00 | 407,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | - |
| 210807 | Газрын төлбөр | 2,966,400.00 | 5,972,970.97 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **1,763,806,859.59** | **1,798,331,555.37** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,341,821.59 | - |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 1,762,465,038.00 | 1,798,331,555.37 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **4,819,000.00** | **1,400,002.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 4,819,000.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 1,400,000.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **-** | **2.00** |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 2.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(526,709,400.74)** | **(881,863,818.40)** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **1,341,821.59** | **-** |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 1,341,821.59 | - |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (1,341,821.59) | - |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(528,051,222.33)** | **(881,863,818.40)** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **14,252,208,234.28** | **21,574,572,441.42** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **410,449,554.28** | **481,097,210.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **410,449,554.28** | **481,097,210.00** |
| 1E+06 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 410,449,554.28 | 481,097,210.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **13,841,758,680.00** | **21,093,475,231.42** |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **-** | **1,124,724,000.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | | 1,124,724,000.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | **13,841,758,680.00** | **19,968,751,231.42** |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 13,841,758,680.00 | 19,968,751,231.42 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **15,372,356,629.10** | **21,521,579,251.42** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **15,372,356,629.10** | **21.521.579.251.42** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **15,367,537,629.10** | **21,520,179,249.42** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **9,285,182,779.91** | **13,477,799,774.00** |
| 210101 | Үндсэн цалин | 5,444,279,907.79 | 7,212,293,640.00 |
| 210102 | Нэмэгдэл | 2,780,581,058.00 | 5,133,688,826.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 338,455,114.12 | 511,510,332.00 |
| 210104 | Урамшуулал | 721,866,700.00 | 620,306,976.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **1,207,084,800.00** | **1,890,788,400.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 820,817,800.00 | 1,332,850,100.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 96,566,700.00 | 139,484,600.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 77,253,300.00 | 69,742,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 19,313,400.00 | 69,742,300.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 193,133,600.00 | 278,969,100.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **1,096,302,546.54** | **1,338,624,398.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 157,181,173.00 | 186,920,954.42 |
| 210302 | Түлш, халаалт | 664,121,373.54 | 886,265,780.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 275,000,000.00 | 265,437,663.58 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **490,057,472.00** | **599,143,950.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 39,990,270.00 | 50,961,240.03 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 235,046,840.00 | 257,070,850.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 10,466,822.00 | 11,629,569.97 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 175,171,250.00 | 226,113,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 29,382,290.00 | 53,369,290.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **3,067,959,426.65** | **3,915,237,896.45** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,634,976,494.65 | 3,397,007,246.45 |
| 210502 | Хоол, хүнс | 397,216,932.00 | 501,564,050.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 35,766,000.00 | 16,666,600.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **121,949,904.00** | **168,621,152.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 42,238,900.00 | 43,092,600.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | - | 1,473,200.00 |
| 210604 | Урсгал засвар | 79,711,004.00 | 124,055,352.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **49,988,200.00** | **74,778,384.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 49,988,200.00 | 74,778,384.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **49,012,500.00** | **55,185,294.97** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 10,800,000.00 | 7,000,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 210,000.00 | 630,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 4,125,900.00 | 7,725,974.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 699,400.00 | 455,350.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 330,000.00 | 407,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | - |

| | | | |
|---|---|---|---|
| 210807 | Газрын төлбөр | 2,966,400.00 | 5,972,970.97 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 29,880,800.00 | 32,994,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **4,819,000.00** | **1,400,002.00** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | - | - |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 4,819,000.00 | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 1,400,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **-** | **2.00** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 2.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **(1,120,148,394.82)** | **52,993,190.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **73,894,140.00** | **54,374,390.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 73,894,140.00 | 54,374,390.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(73,894,140.00)** | **(54,374,390.00)** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | - | - |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | (1,194,042,534.82) | (1,381,200.00) |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 1,195,506,534.82 | 1,464,000.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 1,464,000.00 | 82,800.00 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/эмчийн өөрчлөлтийн тайлан**

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 4,633,020,649.16 | 8,321,850,197.74 | 19,307,271,186.89 | 0.00 | 32,262,142,033.79 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **4,633,020,649.16** | **8,321,850,197.74** | **19,307,271,186.89** | **0.00** | 32,262,142,033.79 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | -524,946,723.10 | 0.00 | -524,946,723.10 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| C08 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **4,633,020,649.16** | **8,321,850,197.74** | **18,782,324,463.79** | **0.00** | 31,737,195,310.69 |
| D01 | **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **4,633,020,649.16** | **8,321,850,197.74** | **18,782,324,463.79** | **0.00** | 31,737,195,310.69 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **4,633,020,649.16** | **8,321,850,197.74** | **18,782,324,463.79** | **0.00** | 31,737,195,310.69 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | 493,323.20 | 0.00 | 493,323.20 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 0.00 | -493,323.20 | 0.00 | 0.00 | -493,323.20 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | | 0.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | -881,863,818.40 | 0.00 | -881,863,818.40 |
| D09 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **4,633,020,649.16** | **8,321,356,874.54** | **17,900,953,968.59** | **0.00** | 30,855,331,492.29 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **24,203,788,900.00** | **21,575,953,639.42** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **24,203,788,900.00** | **21,575,953,639.42** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **24,202,324,900.00** | **21,574,553,639.42** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **14,736,881,800.00** | **13,477,799,774.00** |
| 210101 | Үндсэн цалин | 7,766,903,000.00 | 7,212,293,640.00 |
| 210102 | Нэмэгдэл | 5,757,123,000.00 | 5,133,688,826.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 530,626,200.00 | 511,510,332.00 |
| 210104 | Урамшуулал | 682,229,600.00 | 620,306,976.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **1,890,788,400.00** | **1,890,788,400.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 1,332,850,100.00 | 1,332,850,100.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 139,484,600.00 | 139,484,600.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 69,742,300.00 | 69,742,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 69,742,300.00 | 69,742,300.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 278,969,100.00 | 278,969,100.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **1,771,114,400.00** | **1,338,624,398.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 157,655,500.00 | 186,920,954.42 |
| 210302 | Түлш, халаалт | 1,288,458,900.00 | 886,265,780.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 325,000,000.00 | 265,437,663.58 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **709,986,700.00** | **618,052,850.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 45,985,000.00 | 54,341,240.03 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 249,440,700.00 | 257,070,850.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 11,931,000.00 | 11,629,569.97 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 340,304,500.00 | 226,113,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 62,325,500.00 | 68,898,190.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **4,752,989,200.00** | **3,915,587,896.45** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 4,356,991,600.00 | 3,397,357,246.45 |
| 210502 | Хоол, хүнс | 379,331,000.00 | 501,564,050.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 16,666,600.00 | 16,666,600.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **205,776,400.00** | **202,736,642.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 71,214,200.00 | 72,502,090.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 1,444,400.00 | 1,473,200.00 |
| 210604 | Урсгал засвар | 133,117,800.00 | 128,761,352.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **75,490,300.00** | **74.778.384.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 75,490,300.00 | 74,778,384.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **59,297,700.00** | **56,185,294.97** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 7,000,000.00 | 7,000,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,520,000.00 | 630,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 7,726,000.00 | 7,725,974.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 478,300.00 | 455,350.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 407,000.00 | 407,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | - |
| 210807 | Газрын төлбөр | 8,166,400.00 | 5,972,970.97 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | - | - |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 34,000,000.00 | 33,994,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,464,000.00** | **1,400,000.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,464,000.00 | 1,400,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **24,203,788,900.00** | **21,574,572,439.42** |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,559,543,800.00** | **1,124,723,998.00** |
| 122005 | Орон нутгийн төсвөөс | 1,559,543,800.00 | 1,124,723,998.00 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **20,889,107,700.00** | **19,968,751,231.42** |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 20,889,107,700.00 | 19,968,751,231.42 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **1,755,137,400.00** | **481,097,210.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,753,344,500.00 | 481,097,210.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 1,792,900.00 | |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | 1,464,000.00 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | 82,800.00 |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | 31.00 | 27.00 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1.00 | 1.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 |
| 610002 | Төсвөөс гадуур байгууллага | | |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 495.00 | 505.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 2.00 | 2.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 376.00 | 381.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 117.00 | 122.00 |
| 620004 | Гэрээт ажилтан | | |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

***Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар***

Баян-Өлгий аймгийн аймгийн Нэгдсэн эмнэлэг нь анхан шатны тусламж, эмчилгээ үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий байгууллага юм.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн зорилгыг "Хүн амд үзүүлэх эмнэлгийн ерөнхий болон төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг дэлхийн хөгжилтэй орны түвшинд ойртуулж , орчин үеийн өндөр технологи нэвтрүүлсэн, чадварлаг багаас бүрдсэн оношилгоо, эмчилгээ, сувилгаа, сургалт судалгааны хоёрдогч шатлалын эрүүл мэндийн байгууллага байх" гэж тодорхойлсон байна.

Дээрх зорилгыг биелүүлэхээр дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

1. Хүний нөөцийн хөгжил
2. Үйлчлүүлэгчдэд ээлтэй орчин бүрдүүлэх

3. Цахим орчныг бүрдүүлэх
4. Эмнэлгийн аппарат тоног төхөөрөмжийн хангалт
5. Тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

***Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар***

Баян Өлгий аймгийн Нэгдсэн эмнэлэг нь Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Засгийн газрын 2023 оны "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн сүлжээнд үнэмлэхгүй хэмжээний өөрчлөлт орсон.

Сангийн сайдын 2023 оны 65 дугаар "Хөтөлбөр батлах тухай" тушаалаар аккруэл суурьт УСНББОУС-ыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь тус аймгийн төсөвт байгууллагуудын санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2021, 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдсэн байна. 2023, 2024 оны баримтын шалгалтыг энэ онд хийхээр болсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн Нэгдсэн эмнэлэг нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

***Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар***

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн даргын 2020 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн 212 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа мөрддөг байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад *нийцсэн,* тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт *тохирсон* байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Аймгийн Нэгдсэн эмнэлэг нь 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 408.69 сая төгрөгөөр буурсан буюу 98 хувь байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 1,464.0 | 82.8 | -1,381.2 |
| Авлага | 595,224.3 | 442,524.9 | -152,699.4 |
| Урьдчилгаа | | | |
| Бараа материал | 1,249,336.6 | 1,195,011.9 | -54,324.7 |
| Үндсэн хөрөнгө | 31,591,677.7 | 31,391,387.6 | -200,290.1 |
| **Нийт хөрөнгө** | **33,437,702.60** | **33,029,007.22** | -408,695.38 |
| Өр төлбөр | 1,700,507.35 | 2,174,003.73 | 473,496.38 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 31,737,195.31 | 30,855,331.49 | -881,863.82 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **33,437,702.60** | **33,029,007.22** | -408,695.38 |

Дээрх хүснэгтээс харахад, мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг дансанд өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан байна.

Оны эхэнд байсан мөнгөн хөрөнгийн 1,4 сая төгрөгийн үлдэгдлийг тайлант онд зарцуулсан байна.

Өмнөх оны авлагыг авсан ба тайлант онд эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээс 437.0 сая, нийгмийн даатгалаас 5.5 төгрөгийн авлага үүсгэсэн байна.

Бараа материалын үлдэгдэл оны эцэст 54.3 сая төгрөгөөр буурсан, үндсэн хөрөнгийн үлдэгдэл оны эхнээс 200,29 сая төгрөгөөр буурсан байна. Богино хугацаат өрийн үлдэгдэл 473.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Бараа материалын үлдэгдэл 54.3 сая төгрөгөөр буурсан байна.Төсвийн хөрөнгөөр 4,702.5 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, 52.0 сая төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авч, 4,417.6 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулж, 391.2 сая төгрөгийн бараа материалыг данснаас акталсан, оны эцэст 1,195.0 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй гарсан байна.

Бараа материалын нийт үлдэгдлийн 60.6 хувь буюу 724.4 сая төгрөгийг эм, эм боох материал эзэлж байна.

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 200.29 сая төгрөгөөр буурсан. Төсвийн хөрөнгөөр 69.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн худалдан авч, бусад эх үүсвэрээр нийт 1,528.85 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан байна. Тайлант онд аймгийн ИТХ-ын хуралдааны тогтоолоор 2024 оны 09 дугаар сарын 24-ний өдрийн 275 дугаар тогтоолоор 917.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг актлсан, ИТХ-ын хуралдааны тогтоолоор 2024 оны 09 дугаар сарын 24-ний өдрийн 271 дугаар тогтоолоор 13.3 сая төгрөгийг шилжүүлсэн байна.

Үндсэн хөрөнгөд 1,798.3 сая төгрөгийн элэгдлийг байгуулж, акталсан ба шилжүүлсэн хөрөнгийн 930.9 сая төгрөгийн элэгдлийг данснаас хассан байна.

Тайлант онд аймгийн Нэгдсэн эмнэлгийн өрийн үлдэгдэл 473.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд: байгууллагад өгөх өрийн үлдэгдэл 1,569.4 сая, татварын өглөг 42.7 сая, түлш халаалтын өглөг 492.2 сая, цэвэр бохир усны өглөг 59.6 сая, хувь хүмүүст төлөх өглөг 10.0 сая төгрөг байна.

Засгийн газрын хувь оролцоо данс тайлант үеийн үр дүнгээр 881.86 сая төгрөгөөр буурсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг эрүүл мэндийн даатгалын сангаас 19,914.2 сая төгрөгийн, өөрийн орлогоос 433.6 сая төгрөгийн, орон нутгийн санхүүжилтээс 1,801.3 сая төгрөгийн нийт 22,149.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, нийт зарлагыг 22,149.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас төсвийг хянаж төсвийн төслийн саналаас 574.6 сая төгрөгөөр бууруулж, 21,574.6 сая төгрөгөөр баталсан байна.

**Төсвийн гүйцэтгэл**

Тайлант оны батлагдсан төсөвт тодотгол хийгдсэн байна.Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 21,575.9 сая төгрөгийг баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 21,575.9 сая төгрөгийн санхүүжилтийг авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 21,575.9 сая төгрөг буюу 100 хувьтай байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/сая төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 71602 | Эмнэлгийн тусламж үйлчилгээ | 20,889.1 | 19,968.70 | -920.4 | 95.59% |
| | Төсвөөс санхүүжих орон нутаг | 1,559.5 | 1,124.7 | -434.8 | 72.12% |
| | Төсөвт байгууллагын өөрийн орлого /үндсэн/ | 1,753.30 | 481.1 | -1272.2 | 27.4% |
| | Төсөвт байгууллагын өөрийн орлого /туслах/ | | | | 0.00% |
| | Харилцах дансны эхний үлдэгдэл | 1,5 | 1.4 | 0.08 | 99.88% |
| | Дүн | 24,203.4 | 21,575.9 | -2,627.5 | 89.14% |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт төсөв аваагүй байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Аймгийн Нэгдсэн эмнэлэг нь 2024 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Аймгийн Нэгдсэн эмнэлэг нь худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж ажиллаагүй байна. Батлагдсан төсвийн хүрээнд 4,702.5 сая төгрөгийн бараа материал, 69.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Айнур гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Д.Назгүл, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн   дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 18,792.1 сая төгрөгөөс 0.5 хувиар буюу 93.9 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 23,879.5 сая төгрөгөөс 0.5 хувиар буюу 119.4 сая төгрөг болж байна.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн нийт орлого, зардалд өмнөх оноос өөрчлөлт орсон байх тул материаллаг байдлыг гүйцэтгэлийн шатанд шинээр тогтоох нь зохимжтой гэж үзлээ.

### 44.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хуулийн хэрэгжилтийн хангаж ажилласан байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллийн хэрэгжилттэй холбоотой зөрчил дутагдал илрээгүй.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийсэн. Аудитаар уулзалт хийж, байгууллагын талаар мэдээлэл, дотоод аудитын талаар мэдээлэл авч, холбогдох ажлын баримтуудыг цуглуулсан.

Нөлөөллийн мэдүүлгийн баримтыг танилцуулж, гарын үсэг зуруулж, уулзалтын тэмдэглэлийг баримтжуулсан.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар Худалдан авсан бараа, ажил үйлчилгээнд төлсөн бүгд 239.8 сая төгрөгийн гүйлгээг тооцооны данс дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан, Цалингийн зардал буюу унаа хоолны хөнгөлөлтийн зардлаас хоолны зардалд 36.9 сая төгрөгийг гүйлгэн зарцуулсан, Нэгдсэн эмнэлэг нь тайлант онд 15446.3 сая төгрөгийн зарлага санхүүжилтээр ажиллаж, зарлагын 68.0 хувийг буюу 10,492.2 сая төгрөгийг цалин, нийгмийн даатгалын шитгэлийн зардалд зарцуулсан, Тайлант онд 32 эмч, эмнэлгийн ажилтан тэтгэвэрт гарч, 24 орон тоонд шинээр эмч, ажилтан авсан ба 11 дүгээр сарын 01-ний өдрөөс "Өлгий-Сансар" орон нутгийн өмчит эмнэлгийн 19 эмч, ажилтныг шилжүүлэн авснаар орон тоо нэмэгдэж оны эцэст нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татвар, үйлдвэрчний эвлэлийн татварт нийт 461.1 сая төгрөгийн өртэй гарсан , Тайлант онд худалдаж авсан бараа, үйлчилгээний зардалтай холбоотой байгууллагуудад төлөх 1,239.8 сая төгрөгийн өртэй гарсан, Тайлант онд тендерийн бус компаниас нийт 102.1 сая төгрөгийн эмийг худалдан авч, үйл ажиллагаандаа зарцуулсан, үндсэн хөрөнгийг шууд гэрээгээр худалдан авахдаа төрийн цахим худалдан авалтыг хэрэгжүүлээгүй зөрчлүүдэд зөвлөмж өгч ажилласан байна.

Аудитын дүнгээр зөвлөмжийг биелүүлж, зөрчлийг арилгаж ажилласан байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | | | | | |
| Албан шаардлага | | | | | |
| Зөвлөмж | 5 | 1,484,647.9 | 5 | 1,484,647.9 | 100% |
| **Нийт дүн** | **5** | 1,484,647.9 | **5** | 1,484,647.9 | **100%** |

## 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлалтаас цалинг тогтоолт, олголтын байдлыг үзэж чадаагүй тул дараагийн аудитаар цалингийн зардлын зарцуулалтыг үзэх нь зүйтэй гэж үзлээ. Өөр анхаарах татах асуудал гараагүй байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,526.0 сая төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад 2,526.0 сая төгрөгийн алдааг залрууллаа.

*Залруулсан алдаа:*

- Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөөг 2,526.0 сая төгрөгөөр дутуу тайлагнасан.

Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллагын санхүүгийн тайлан гаргах заавар аргачлал, УСНББОУС 1 стандарт, толилуулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар зөрчил дутагдал илрээгүй байна.

### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй.

### 5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй.

### 5.3 Зөвлөмж

Зөвлөмж өгөгдөөгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөөг дутуу тайлагнасан | 1 | 2,629,113.2 | 0 | 0 | 1 | 2,629,113.2 | 1 | 2,629,113.2 | | | | |
| **Дүн** | 1 | 2,629,113.2 | 0 | 0 | 1 | 2,629,113.2 | 1 | 2,629,113.2 | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | |